



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар A/129

Мандалговь


Г Гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/99 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх "Төв халхын дуулалт жүжгийн театрын дээврийн засвар"-ын ажлын гүйцэтгэгчээр "Баянгийн говь" ХХК-ийг сонгон 37,900,000 / гучин долоон сая есөн зуун мянга / төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу засварын ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг "Баянгийн говь" ХХК -ний захирал /Л.Эрдэнэбүд/-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу гүйцэтгэж буй ажилд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Төв халхын дуулалт жүжгийн театр /Д.Доржсүрэн/-д үүрэг болгосугай.



0300390